



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Монгол Улсад Бизнесийн Ёс Зүйг Дэмжих нь: Сайн туршлага ба амжилтын түүхүүдийн нэгтгэл



2018 он

Монгол Улсад Бизнесийн Ёс Зүйг Дэмжих нь: Сайн туршлага ба амжилтын түүхүүдийн нэгтгэл

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) нь Азийн Сантай хамтран шилдэг туршлага, эерэг түүхүүдийг сурталчлах замаар Монголд бизнесийн ёс зүйг хөхүүлэн дэмжиж, улмаар авилгын эсрэг соёл ба зан үйлийг нийгэмд, тэр дундаа хувийн хэвшилд бий болгоход үр дүнтэй хувь нэмэр оруулах зорилготойгоор ажиллаж байна.

Энэхүү нэгтгэл нь манай танхимын гишүүдийн ёс зүйн дүрэм, бэлэг өгөх ба засгийн газартай харилцах журам; ашиг сонирхлын зөрчлийг удирдах; компанийн ил тод байдал ба тайлан тавих; ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, авилгалтай холбоотой бэрхшээлүүд болон хэргүүд зэрэгтэй холбогдох баримт бичгүүдийг судлах, мөн тодорхой гишүүдтэй одоо байгаа баримт бичгүүдээс гол зүйлсийг тоймлоход хамтран ажилласны үр дүнд гарсан бичиг баримт билээ.

Тус баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам Монголоос зөвшөөрөл авна.

Зохиогчийн эрх © Монгол дахь Америкийн Худалдааны Танхим

2018 оны 11 сар, Улаанбаатар хот

Оршил

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) нь Азийн Сантай хамтран шилдэг туршлага, эерэг түүхүүдийг сурталчлах замаар Монголд бизнесийн ёс зүйг хөхүүлэн дэмжиж, улмаар авилгын эсрэг соёл ба зан үйлийг нийгэмд, тэр дундаа хувийн хэвшилд бий болгоход үр дүнтэй хувь нэмэр оруулах зорилготойгоор ажиллаж байна.

Энэхүү нэгтгэл нь манай танхимын гишүүдийн ёс зүйн дүрэм, бэлэг өгөх ба засгийн газартай харилцах журам; ашиг сонирхлын зөрчлийг удирдах; компанийн ил тод байдал ба тайлан тавих; ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, авилгалтай холбоотой бэрхшээлүүд болон хэргүүд зэрэгтэй холбогдох баримт бичгүүдийг судлах, мөн тодорхой гишүүдтэй одоо байгаа баримт бичгүүдээс гол зүйлсийг тоймлоход хамтран ажилласны үр дүнд гарсан бичиг баримт билээ.

Тус нэгтгэл нь мөн баялаг мэдлэг мэдээлэл, туршлагыг Монгол дахь ижил бодлогын хүрээ, зохицуулалт байхгүй өргөн хүрээний бизнес эрхлэгч нарт, ялангуяа Жижиг, дунд үйлдвэрлэгч (ЖДҮ)-дэд түгээх арга замын талаар тоймлон гаргасан.

Эдгээр туршлагуудын үндсэн шинж ба нөлөө, тэдгээрийг хуулбарлан давтах боломж, мөн ёс зүйтэй бизнесийн шинэ чиг хандлагуудыг тодорхойлоход сонгогдсон аж ахуй нэгжүүдтэй дахин хамтран ажиллах болно.

Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын гишүүд нь ил тод, хариуцлагатай байдлыг хангах өндөр стандарт бүхий ёс зүйн дүрэм, засгийн газартай харилцах харилцааг зохицуулах нарийн дүрэм, авилгалаас урьдчилан сэргийлэх тогтолцоотой олон улсын болон үндэсний тэргүүлэгч компаниудын төлөөллөөс бүрддэг.

Энэхүү нэгтгэлд Монгол улсын нөхцөлд олон улсын стандартыг хэрхэн нэвтрүүлж буй болон дотоодын дүрэм журамд хэрхэн нийцүүлж буй компаниудын жишээг харуулав. Үүнд:

Оюу Толгой компани нь ёс зүйтэйгээр бизнес эрхлэх явдлыг дэмжих цогц тогтолцоо, бодлогын баримт бичгүүдтэй бөгөөд үүнд бүх төрлийн хээл хахууль, авилгыг хориглосон Бизнесийн ёс зүйн зарчмуудыг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс зайлсхийх, илрүүлэх, залиланг хориглох, мэдээллийн нууцлалыг хадгалах, итгэлцлийг бий болгох, болзошгүй зөрчлийн талаар илэн далангүй ярилцах явдлыг дэмжих бодлогууд багтсан байдаг байна.

Маш чухал бодлогын тогтолцоо нь өндөр мэдрэмж, сэрэмжтэй удирдлага шаарддаг Оюу Толгойн худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой байдаг. Тус компани нь Оюу Толгойн төсвийн зарцуулалтын шаардлагын хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа компанийн худалдан авалт хариуцсан ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгч нар мөрдвөл зохих Худалдан авалт хариуцсан ажилтны удирдамжийг тодорхойлон мөрддөг.

Үүний зэрэгцээ, Оюу Толгой компани нь боломжит нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм, шударга ёс, улс төр болон бусад харилцаа холбоог үнэлэхийн тулд гуравдагч талын магадлан шинжилгээ хийдэг.

М-Си-Эс Холдинг нь бүх үйл ажиллагаа, охин компаниудынхаа хүрээнд ёс зүйн дүрмийг хэрэгжүүлдэг дотоодын тэргүүлэх компаниудын нэг юм. Бүх ажилчид, ханган нийлүүлэгчид болон гэрээт ажилчид нь Ёс зүйн дүрмийг адилхан дагаж мөрдөх ёстой. Энэхүү баримт бичиг нь М-Си-Эс Группийн үнэт зүйл, зарчмууд, ажилчдад зориулсан ёс зүйн дүрэм, ашиг сонирхлын зөрчил, засгийн газрын харилцаа, тайлан тавихыг тодорхойлдог.

Хас Банк нь үйлчлүүлэгчээ таних, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн болон байгаль орчны эрсдэлийн удирдлага, ёс зүйтэй санхүү, ёс зүйн дүрэм гэсэн таван үндсэн зарчмыг баримталдаг цогц тогтолцоотой аж ахуй нэгжийн жишээ юм.

Баримт бичгийн судалгааны тойм

Нийцлийн тухай сэдэв нь Монгол улсын хувийн хэвшил, төрийн өмчийн компаниуд болон компанийн засаглалын хүрээнд хөгжиж буй харьцангуй шинэ ойлголт бөгөөд Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн охин компани болох **Тэнгэр Даатгалын** хувьд компанийн засаглалын хүрээнд дээрхийг боловсруулж байгаа юм.

Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ) нь Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компанитай (НХСК) хамтран 2012 оноос байгаль орчин, нийгмийн хариуцлагын эрсдэлийн удирдлагын системийг хэрэгжүүлж эхэлсэн ба энэ нь урьд өмнө нь Монгол улсын хувьд үл мэдэгдэх ойлголт байсан. ХХБ тус системээр дамжуулан хариуцлагатай санхүүгийн механизмыг танилцуулж, санхүүжилтийн үр нөлөөг үнэлэн, байгаль орчин, нийгэмд хор хөнөөл учруулж болзошгүй санхүүгийн төслүүдээс зайлсхийсэн ба ажилчдаа ялангуяа зээлийн мэргэжилтнүүдээ байгаль орчин, нийгмийн нөлөөллийн шинжилгээ хийхэд сургасан байна.

Вагнер Ази Тоног Төхөөрөмж нь Чанарын удирдлагын систем ISO 9001:2005 - олон улсын стандартын дагаж мөрдөж буй аж ахуй нэгжийн жишээ юм. Энэхүү бодлого нь Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-ий Бүтээгдэхүүн Дэмжих Газар ба түүний охин компаниуд чанарын болон байнгын сайжруулалтыг хэрхэн зохицуулах талаар агуулжээ. Захирал болон ажлын хэсгүүдийн Ерөнхий менежерүүд нь өөрсдийн ажилтнуудыг олон улсын стандарт ба/эсвэл хүлээгдэж буй гэрээний стандартыг мэдэж байгаа эсэхийг баталгаажуулах үүрэгтэй. Бүх ажилчид бүтээгдэхүүн, үйл ажиллагаа эсвэл үйлчилгээг сайжруулах талаар саналаа шууд удирдлагадаа мэдэгдэх боломжтой ба хэрэв тухайн саналыг удирдлагаас зөвшөөрсөн тохиолдолд хэрэгжүүлэх боломжтой.

МСМ Групп ХХК (МСМ) нь төрийн албан хаагчидтай харилцах тодорхой зааварчилгаатай ба үүнд (i) МСМ-ийн зүгээс аливаа улс төрийн нам, хороо, нэр дэвшигч эсвэл улс төрийн албан тушаалтанд улс төрийн төлбөр, бэлэг, зээл, үйлчилгээг зөвхөн холбогдох хууль, дотоод бодлогын дагуу МСМ-ийн Удирдах Зөвлөлөөс урьдчилан зөвшөөрсөн тохиолдолд олгож болох ба (ii) МСМ болон тус компанийн охин компаниуд, салбар компаниуд, бусад хүмүүсээс бизнес олж авах, хадгалан үлдэх, чиглүүлэх зорилгоор улс төрийн албан хаагч, ажилтанд аливаа төлбөр, аж ахуй нэгж, охин компани, хувийн зээлийн төлбөр эсвэл бусад үнэ бүхий зүйлийн шилжүүлэг хийхийг хориглоно.

ING Банк нь хээл хахууль, авилгын эсрэг Үл тэвчих аргыг баримталдаг. 2015 онд ING Банк Улбар шар кодыг авч хэрэгжүүлсэн. “Нэн тэргүүнд Шударга байдал” зорилгыг хэрэгжүүлэхээр зорьсон энэхүү тогтоолоороо үйлчлүүлэгчидтэйгээ итгэлтэй харилцааг бэхжүүлэхээр төлөвлөсөн. Улбар шар кодонд ING Банкны үнэт зүйлс (шударга, хянамгай, хариуцлагатай), зан үйл болон ING Банк дотор аливаа сэжиг бүхий эсвэл бодит гэмт хэрэг, ёс суртахуунгүй үйл ажиллагаа, бусад буруутай үйлдлүүдэд хамааралтай 'шүгэл үлээгч' бодлогоор хэрэгжих хээл хахууль, авилгын эсрэг бодлогууд багтдаг байна.

Үүний адил **Саусгоби Сэндс ХХК** нь Бидний ажлын арга барил баримт бичгийг бизнесийн ёс зүйн дүрмийн үндэс болгон ашигладаг. Бидний ажлын арга барил нь шударгаар бизнесээ эрхлэх үүрэг болон тогтвортой хөгжилд хүрэх компанийн засаглалын нарийн стандартыг тусгасан байдаг. Тогтвортой хөгжлийн үүргээ биелүүлнэ гэдэг нь тогтвортой хөгжлийн асуудлуудыг бизнес төлөвлөгөө, шийдвэр гаргах үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгохыг хэлнэ.

Мөн **Камминс, Делойтт, PwC, Crown** зэрэг компаниуд нь ёс зүйн дүрмийн олон улсын туршлагыг Монголын нөхцөлд хэрэгжүүлж буй бизнесүүдийн жишээ юм.

Монгол улсын ЖДҮ-д авч хэрэгжүүлэх боломжтой арвин мэдлэг, туршлага АмЧам-ын гишүүдэд байна.

Гишүүдтэй хийсэн ганцаарчилсан хэлэлцүүлгээр мэдлэг хуваалцах, түгээх зарим арга замуудыг тодорхойлсон ба тэдгээр нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

Мэдлэг түгээх,
хуваалцах
арга замууд



- Томоохон хэмжээний форум;
- АмЧам-ын гишүүд кейс судалгаа танилцуулж болох салбар салбарын компаниудыг цуглуулсан сэдэвчилсэн семинар;
- Тэнхимийн сургалтын хөтөлбөрүүд;
- Сургалтын цогц хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хөндлөнгийн аудитын шалгалт, зөвлөмж;
- Бизнесийн сайн ёс зүйн бичиг баримтын загвар гаргаж өгөх;
- Туршлага солилцох.

Жишээлбэл, Оюу Толгой компани нь Олон Улсын Санхүүгийн Байгууллага (IFC) болон ХБНГУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран Монголын ЖДҮ-үүдийн “Чадварыг бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн гол зорилго нь ЭМААБО, бизнесийн шударга байдал, бизнесийн удирдлага, нийлүүлэлтийн сүлжээний удирдлага зэрэг төрөл бүрийн ажил хэргийн харилцааны дадлага, туршлагын шаардлагатай сургалтуудыг ЖДҮ-үүдэд явуулж, тэдний өрсөлдөх чадвар, тогтвортой байдлыг сайжруулахын зэрэгцээ дэлхийн жишгийн уул уурхайн болон бусад салбарын хэрэгцээг хангаж, санхүүгийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг дэмжихэд оршино.

Энэхүү хөтөлбөр нь ЖДҮ-үүдийг олон улсын жишигт нийцсэн стандартуудыг боловсруулж, ханган нийлүүлэгч болох ховор боломжийг олгодог.

Оюу Толгой компани хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзан боловсон хүчнээ бүрдүүлдэг, түүнчлэн Өмнөговь аймагт жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх замаар орон нутгийн эмэгтэйчүүдийн эдийг засгийг чадавхжуулах, тэтгэлэгтэйгээр сурах боломж олгож, үндэсний хэмжээнд төсөл хөтөлбөрийг нь ивээн тэтгэж, хамтран хэрэгжүүлдэг. Тухайлбал, Оюу толгой компанийн дээрх алхамуудыг харуулах нэг гайхалтай жишээг энд дурдъя: [Оюу Толгойн](#) анхны эмэгтэй тэсэлгээчин болохыг зорьж буй уурхайчин бүсгүй Ш.Даваасүрэн цахилгааны инженер мэргэжилтэй, Оюу толгойн уурхайн бүтээн байгуулалтад гар бие оролцож байгаа 2,500 гаруй эмэгтэйчүүдийн нэг юм. Оюу толгойн ажилтан болсныхоо дараа ахлах ажилтныхаа санал болгосноор сургалтад хамрагдаж амжилттай төгссөнөөр тэсрэх бодистой харилцах эрхийн үнэмлэх гардсан Оюу толгойн анхны эмэгтэй уурхайчин болжээ. Тэрээр өнөөдрийг хүртэл амжилттай ажиллаж яваагаа ахлах ажилтан болон хамт олонтойгоо холбон тайлбарлаж, гадаад мэргэжилтний мэдлэг, туршлагаас тасралтгүй суралцахын зэрэгцээ ажилтан бүрийнхээ өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг нь дэмжин, дээшилж дэвжих боломжоор хангаж, өөрийгөө шинэ зүйлд сорихыг зөвлөдөг юм. Ш.Даваасүрэн тэсрэх бодистой харьцах эрхтэй ч тэсрэх бодист гал өгөх эрх авах зорилготой байгаа бөгөөд 2019 он гэхэд ийм эрх авсан анхны эмэгтэй болох зорилготой ажиллаж байна.

Сайн туршлагуудыг хуваалцах өөр нэг арга бол АмЧам-ын гишүүдийн түгээмэл хэрэглэдэг тунхаглал, гарын авлага, онлайн маягт, бүртгэлийн систем зэрэг бэлэг/урамшууллын талаарх мэдээллийг ил болгох тогтолцоо, үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх юм. Жишээ нь, бид гишүүддээ болон сонирхсон Монголын компаниудад бэлэг/урамшууллын талаарх мэдээллийг ил болгох журам, үйл ажиллагааны талаар цогц сургалт зохион байгуулах эсвэл сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлж болно.

АмЧам нь сонирхсон Монголын ЖДҮ-үүдийн ёс зүйн дүрэм; бэлэглэх болон төрийн байгууллагуудтай харилцах харилцааны зохицуулах журам; ашиг сонирхлын зөрчлийн удирдлага; компаний ил тод байдал ба тайлан тавих; ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, авилгатай холбоотой бэрхшээлүүд болон хэргүүдтэй холбоотой баримт бичгүүдийг шалгах зорилгоор холбогдох гишүүдээс хөндлөнгийн аудит зохион байгуулах эсвэл мэргэжилтнүүдийг томилохыг хүсэх боломжтой. Эдгээр мэргэжилтнүүд дээр дурдсан чиглэлүүдийн хүрээнд Монголын ЖДҮ-үүдэд сайжруулах санал зөвлөмжийг гаргах боломжтой юм.



Үүнээс гадна АмЧам нь Азийн Сангаар дамжуулан Монголын ЖДҮ-үүдтэй гишүүдийнхээ шилдэг туршлагаудад үндэслэн бизнесийн сайн ёс зүйн талаарх бичиг баримтын загварыг боловсруулж болно. Тус загварт ёс зүйн дүрмийн хамгийн наад захын шаардлагуудыг багтаасан байх ба ингэснээр Монголын ЖДҮ эрхлэгчид өөрсдийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн өөрчлөн, хэрэгжүүлэх боломжтой болно.

Цаашилбал АмЧам нь гишүүд болон Монголын ЖДҮ эрхлэгчдийн хооронд харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулж болно. Энэ нь Монголын ЖДҮ-үүд өөрсдийн ажилтнуудаас АмЧам-ын гишүүн компаниуд руу явуулж (эсвэл эсрэгээр нь) холбогдох туршлага судлан, мэдлэг олж авах боломжтой гэсэн үг юм.

Эцэст нь дээрх мэдлэг хуваалцах, түгээх аргууд нь Монголын АмЧам-ын гишүүдийн шилдэг туршлагаудыг Монголын ЖДҮ-үүдэд хуулбарлан нэвтрүүлэх, ингэснээр тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хариуцлагатай бизнес болох явдлыг баталгаажуулах юм.





The *AMERICAN CHAMBER* of Commerce in Mongolia



www.amcham.mn